

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/01/НА-СТА-ТЕЗ

ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: Khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: Amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 702723204 Цахим хаяг: Sarachimegts@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: Khurelbaatar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын илрүүлэлт	8
3.1 Залруулсан алдаа	8
3.2 Төлбөрийн акт.....	9
3.3 Албан шаардлага.....	10
3.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.....	13
3.5 Зөвлөмж	13
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16
5. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	17

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Л.ТӨМӨРЧӨДӨР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 3,072.2 сая төгрөгийн авлага, 377.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй, Эмийн эргэлтийн сангийн авлагын үлдэгдэл 389.8 сая төгрөг болж, өмнөх оноос 149.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, Засаг даргын ерөнхий данснаас 381.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 114.2 сая төгрөгийн бараа материалыг орлого аваагүй, 267.0 сая төгрөгийн ногоон тэжээлийг үнэ төлбөргүй олгосон боловч анхан шатны баримт, бараа материалын тайлангүй, Засаг даргын ерөнхий данснаас "Өөрчлөлтгүй" санал дүгнэлтийг үндэслэн аймгийн ЗДТГ-ын санхүү, бүртгэлийн нийт 10 албан хаагчдад 21.3 сая төгрөгийн шагналыг бараа үйлчилгээний бусад зардлаас олгосон, Аймаг хөгжүүлэх сангийн 6,201.9 сая төгрөгийн зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд байршуулаагүй, Мал хамгаалах сангийн 229.8 сая төгрөгийн нөөцийн өвс, тэжээлийн үлдэгдлийг бодитоор оршин буйг нотлох боломжгүй, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс Заамарын хөгжил, Сэргэлэн нутгийн хөгжил ОНӨААТҮГ-ууд алдагдалтай ажилласан, Эко төв Жаргалант ОНӨААТҮГ, Шимт бордоо органик ХХК үйл ажиллагаа явуулаагүй, мөн өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

412502365

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Төрийн аудитын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заасантай тус тус нийцэхгүй санхүүгийн "иж бүрэн байх", "оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 27 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч, 64 төсөвт байгууллага, 103 тусгай зориулалттай сан, 11 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, нийт 205 санхүүгийн тайланд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаар хуралдааны "Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг дүгнэх тухай" 01 дүгээр тогтоолоор 37 зорилт, 173 арга хэмжээний хэрэгжилтийг 90,4 хувийн гүйцэтгэлтэй буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт дүгнэх тухай" 02 дугаар тогтоолоор 52 зорилт, 274 арга хэмжээний хэрэгжилтийг 88,4 хувийн гүйцэтгэлтэй буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна. Мөн "Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт дүгнэх тухай" 03 дугаар тогтоолоор 35 зорилт, 200 арга хэмжээ 87,1 хувийн гүйцэтгэлтэй "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж тус тус дүгнэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Төв аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2024 оны батлагдсан төлөвлөгөөгөөр орлого эх үүсвэрийг 159,896.4 сая төгрөгөөр бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 131,576.0 сая төгрөгийг бүрдүүлж 28,320.4 сая төгрөгөөр дутуу буюу 82,3 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 74,534.0 сая төгрөгийн зөрчил илэрч, 20 байгууллага "хязгаарлалттай", 1 байгууллага "татгалзсан" дүгнэлт авсан байна.

Харьяа байгууллагуудын алдаа зөрчлийг нэгтгэн дүгнэхэд дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд: Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоог бодоогүй, бараа материалыг акталж данснаас хасахдаа өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гараагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг буруу тооцсон, татварын болон

татварын бус орлогыг нэр төрлөөр бүрэн биелүүлээгүй, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй, Монгол банкны мэдээллийн санд зээлийн үлдэгдлийн мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн, худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй, зардлын эдийн засгийн ангиллыг зөрчин зарцуулсан зэрэг зөрчлүүд нийт зөрчлийн 34,0 хувийг эзэлж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой байршуулбал зохих мэдээллийг тогтсон хугацаанд, тогтмол, үнэн зөв мэдээлээгүй зөрчил нь нийт зөрчлийн 64,0 хувийг эзэлж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		66,521,259.8	90,967,952.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	37,337,641.8	52,892,396.4
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	21,750,907.1	26,534,897.5
УРЬДЧИЛГАА	7а, 7б	59,798.5	24,012.6
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	7,358,863.5	11,476,716.1
НӨӨЦИЙН БАРАА	9а	14,048.9	39,930.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		135,801,585.3	174,533,262.9
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	135,801,585.3	174,533,262.9
Биет хөрөнгө		127,511,472.8	147,927,812.4
Биет бус хөрөнгө	13	8,284,522.5	26,599,860.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		202,322,845.1	265,501,215.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР		6,609,341.1	5,131,324.7
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	5,646,931.1	4,257,638.7
Өглөг	17а, 17б	5,561,928.0	4,047,802.6
Урьдчилж орсон орлого	18а, 18б	85,003.1	209,836.1
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		962,410.1	873,686.0
Урт хугацаат зээл	20а, 20б	962,410.1	873,686.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		195,713,503.9	260,369,891.1
Засгийн газрын хувь оролцоо		195,713,503.9	260,369,891.1
Засгийн газрын оруулсан капитал		32,806,806.8	32,806,806.8
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		11,322,183.3	10,587,992.0
Хуримтлагдсан үр дүн		135,637,609.6	200,455,761.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		15,946,904.2	15,705,925.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		202,322,845.1	265,501,215.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		175,536,337.4	211,929,413.5
ТАТВАРЫН ОРЛОГО		56,538,510.5	82,091,630.2
Орлогын албан татвар		34,020,371.4	54,499,538.4
Хувь хүний орлогын албан татвар		26,076,528.2	42,644,218.3
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-898,431.2	-1,375,642.8
ААН-ын орлогын албан татвар		8,842,274.5	13,230,962.9
Хөрөнгийн албан татвар		12,007,621.4	14,199,350.9
Бусад татвар, төлбөр, хураамж		10,510,517.7	13,392,740.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	89,403,991.0	122,253,025.1
Нийтлэг татварын бус орлого		55,240,989.5	75,581,263.8
Хөрөнгийн орлого		333,803.4	647,431.9
Тусламжийн орлого		1,362,033.7	1,788,162.4
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		32,467,164.4	44,236,167.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		29,593,835.9	7,584,758.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	93,602,475.6	129,647,447.9
УРСГАЛ ЗАРДАЛ		82,349,923.5	110,239,498.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		80,473,885.2	107,269,040.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		21,536,882.8	31,252,821.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,761,636.2	3,933,432.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		10,831,512.6	24,310,291.1
Хангамж, бараа материалын зардал		2,277,990.4	2,810,208.2
Норматив зардал		1,812,147.8	2,327,577.0
Эд хогшил, урсгал засварын зардал		376,892.5	1,337,107.9
Томилолт, зочны зардал		246,485.1	465,313.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,633,151.4	4,672,557.5
			36,159,731.4

**Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн аудитын тайлан**

ХҮҮ		883,050.9	125,714.0
ТАТААС		0.0	198,162.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		992,987.4	2,646,582.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		11,252,552.2	19,407,949.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		81,933,861.8	82,281,965.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		427.0	166.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		51,098,849.9	21,440,245.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		30,835,438.8	60,841,886.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	148,979,595.3	170,947,039.5
ТАТВАРЫН ОРЛОГО	55,147,067.6	82,227,203.3
Орлогын албан татвар	32,578,253.6	54,635,111.5
Хувь хүний орлогын албан татвар	26,076,528.2	42,779,791.5
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-872,488.4	-1,375,642.8
ААН-ын орлогын албан татвар	7,374,213.9	13,230,962.9
Хөрөнгийн албан татвар	12,007,621.4	14,199,350.9
Бусад татвар, төлбөр, хураамж	10,561,192.6	13,392,740.8
Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,191,089.0	4,985,998.6
Газрын төлбөр	3,026,223.8	3,704,276.3
Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,343,879.8	4,702,465.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,925,865.0	82,839,950.9
Нийтлэг татварын бус орлого	30,792,127.2	36,185,860.3
Хөрөнгийн орлого	333,803.4	647,431.9
Тусламжийн орлого	3,332,770.0	1,770,491.6
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	32,467,164.4	44,236,167.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,906,662.7	5,879,885.3
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,286,922.7	97,957,829.8
УРСГАЛ ЗАРДАЛ	72,286,922.7	97,957,829.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,194,048.6	95,040,913.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,191,425.0	31,104,348.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,836,335.6	4,971,151.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,350,080.0	25,902,915.6
Хангамж, бараа материалын зардал	3,969,082.6	4,170,717.6
Норматив зардал	1,793,814.0	2,329,518.7
Эд хогшил, урсгал засварын зардал	405,083.6	1,673,666.1
Томилолт, зочны зардал	243,173.5	463,858.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,758,727.4	4,156,518.2
Бараа үйлчилгээний бусад зардал	22,646,326.9	20,268,218.5
ХҮҮ	883,050.9	125,714.0
ТАТААС	102,000.0	198,162.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,107,823.2	2,593,040.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	76,692,672.6	72,989,209.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	71,870,228.6	54,450,692.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	71,870,228.6	54,450,692.5
Дотоод эх үүсвэрээр	71,870,228.6	54,450,692.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-71,870,228.6	-54,450,692.5
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-4,437,520.4	-2,979,420.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,437,520.4	2,946,944.6
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	384,923.6	15,559,096.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,963,904.7	37,337,641.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,337,641.8	52,892,396.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,580,520.1	162,580,520.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	162,936,031.9	162,936,031.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-47,679.3	-47,679.3
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,989,712.5	1,989,712.5
Тайлант үеийн үр дүн	30,835,438.8	30,835,438.8
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,713,503.9	195,713,503.9
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	195,713,503.9	195,713,503.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,940,496.9	3,940,496.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	199,654,000.9	199,654,000.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-975,170.3	-975,170.3
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-3,716.1	-3,716.1
Өмчид гарсан өөрчлөлт	852,890.3	852,890.3
Тайлант үеийн үр дүн	60,841,886.3	60,841,886.3
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	260,369,891.1	260,369,891.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	159,864,521.4	125,712,368.1
УРСГАЛ ЗАРДАЛ	82,453,663.0	71,839,916.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,075,285.2	70,591,323.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,510,271.2	24,284,527.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,196,015.6	2,996,936.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,092,256.3	20,555,313.3
Хангамж, бараа материалын зардал	1,500,773.8	1,409,132.2
Норматив зардал	276,537.7	273,896.7
Эд хогшил, урсгал засварын зардал	2,395,346.7	2,278,434.5
Томилолт, зочны зардал	465,310.1	421,669.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,449,801.5	3,334,510.0
Бараа үйлчилгээний бусад зардал	22,188,972.3	15,036,903.6
ХҮҮ	125,714.0	125,714.0
ТАТААС	198,162.0	198,162.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	198,162.0	198,162.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,054,501.8	924,717.2
Бусад урсгал шилжүүлэг	1,005,301.8	884,717.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	73,659,577.7	52,447,506.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,751,280.7	1,424,944.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	159,864,521.4	131,576,025.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,366,758.3	0.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	98,423,833.5	127,299,928.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	30,515,818.2	2,505,604.8
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	2,558,111.4	1,770,491.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	5,698,099.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	11,642,017.6
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,081	2,055
БАЙГУУЛЛАГЫН ТОО	63	63
Төсвийн байгууллага	63	63
АЖИЛЛАГСДЫН ТОО	1,009	996
Удирдах ажилтан	252	251
Гүйцэтгэх ажилтан	415	408
Үйлчлэх ажилтан	131	131
Гэрээт ажилтан	211	206
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,009	996
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	416	408
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	227	226
Гэрээт ажилтан	180	175

Улс төрийн албан хаагч (УТ)	182	183
-----------------------------	-----	-----

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,144,184.4	16,990,556.6
УРСГАЛ ЗАРДАЛ	6,740,293.4	12,210,284.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,281,778.8	9,072,613.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,310,820.3	3,003,718.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,172.1	353,789.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,604.0	13,048.1
Хангамж, бараа материалын зардал	84,167.4	237,841.4
Эд хогшил, урсгал засварын зардал	95,054.1	86,792.9
Томилолт, зочны зардал		35,461.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,390.1	86,351.2
Бараа үйлчилгээний бусад зардал	3,398,570.8	5,255,609.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,458,514.5	3,137,671.7
Бусад урсгал шилжүүлэг	412,685.0	1,592,010.4
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,045,829.5	1,545,661.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,403,891.0	4,780,271.7
Дотоод эх үүсвэрээр	1,403,891.0	4,780,271.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,144,184.4	17,023,032.6
Нэмэлт санхүүжилтийн орлого	8,144,184.4	17,023,032.6

3. Аудитын илрүүлэлт

3.1 Залруулсан алдаа

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,062.1 сая төгрөгийн 7 алдаа¹ илэрснээс, аудитын явцад 9,062.1 сая төгрөгийн 7 алдааг залрууллаа. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн тохируулгыг Барилга захиалагч орон сууцны корпорац, Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ, Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагууд 27.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө дансыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн хандив тусламж, бусад хөрөнгө, дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэлтэй тулгахад Хот тохижуулах газар 6,383.4 сая төгрөг, Угтаалцайдам сумын ЗДТГ 170.7 сая төгрөг, Борнуур сумын ЗДТГ 63.3 сая төгрөгөөр нийт 6,617.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн тохируулгыг Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар, Бүрэн сумын ИТХ, Төв аймгийн ИТХ зэрэг байгууллага 123.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- Сэргэлэн сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,186.7 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, татаас санхүүжилтийн авлагыг тайлагнаагүй байна.
- Аймаг хөгжүүлэх сангийн санхүүгийн байдлын тайланд авлагын эхний үлдэгдэл 100.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- Аймаг хөгжүүлэх сангийн санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийг 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Аймаг хөгжүүлэх сангийн санхүүгийн үр дүнгийн тайланд үйлчилгээний орлого 1,004.4 сая төгрөгийг хүүгийн орлого, үндсэн зээлийн орлогоор тус тус салгаж тайлагнаагүй байна.

Эдгээр алдаа нь: УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын гол дүгнэлтэд “Санхүүгийн тайлан нь байгууллагын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээний талаар үнэн зөв, бодит мэдээллийг өгч байх ёстой”.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”
- Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.5-д “Төв төрийн сан өдөр тутмын орлого, зарлагын гүйлгээг холбогдох системд бүртгэж, үр дүнг Монгол банк дахь төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлтэй тулган зөрүүг тухай бүр залруулах арга хэмжээ авна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 7,600.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,921.8 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөгдсөн байна.

3.2 Төлбөрийн акт

Илрүүлэлт: 1 Аймаг хөгжүүлэх сангаас томилолтын хуудасгүй, анхан шатны баримтын бүрдэл болоогүй 1,560.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг гаргаж авлагаар тусгасан зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр

зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтын дагуу төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт: 2 Аймаг хөгжүүлэх сангийн нягтлан бодогч Х.Дуламсүрэн өөрийн хувийн 5743071265 тоот дансанд 0.3 сая төгрөгийн шатахууны зардал шилжүүлж, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил илэрсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтын дагуу төлбөрийн акт тогтоов.

3.3 Албан шаардлага

Илрүүлэлт: 1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын 11,5 хувь болох 3,072.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан байна. Мөн өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн аудитын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-д "Хууль

тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: 2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар эмийн эргэлтийн сангийн авлагын үлдэгдлийг насжилтаар авч үзэхэд 2-5 жил болсон 153,042.5 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" 12 дугаар зүйлийн 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: 3 Засаг даргын ерөнхий данснаас 2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг цаг хугацаанд нь чанартай, үнэн зөв, бүрэн гарган "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт авсан гэх үндэслэлээр тайлант оны 10 дугаар сард аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, бүртгэлийн нийт 10 албан хаагчдад 21.3 сая төгрөгийн шагналыг бараа үйлчилгээний бусад зардлаас олгосон зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: 4 Засаг даргын ерөнхий данснаас тайлант онд 381.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 114.2 сая төгрөгийн бараа материалыг орлого аваагүй, бараа материалын тайлан үйлдэж тооцоо бодоогүй байна. Мөн 267.0 сая төгрөгийн 13,000 боодол ногоон тэжээлийг зарцуулсан анхан шатны баримт, бараа материалын тайлан үйлдээгүй, тооцоо бодоогүй зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "Хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.3.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх", 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: 5 Аймаг хөгжүүлэх сангийн зээлийн авлагын судалгаагаар нийт 293 иргэнтэй холбоотой 6,201.9 сая төгрөгийн авлагаас, 134 иргэнтэй холбоотой 2,826.6 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн зээлтэй бөгөөд зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд байршуулаагүй зөрчил илэрсэн байна. Энэ нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Иргэний хуулийн 451.1-д заасны дагуу зээлийн гэрээгээр банк, эрх бүхий хуулийн этгээд нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь зээлийн гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, зээлийн гэрээнд заасан бол хүүг буцаан төлөх үүргийг хүлээнэ", Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр хуралдааны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Аймаг хөгжүүлэх сангийн журам"-ын 4.13-д "Сангийн хөрөнгийг журамд заасан зориулалтын дагуу аймгийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн зарцуулах ба зориулалт бусаар зарцуулахыг хориглоно", Аймаг хөгжүүлэх сангийн зээлийн гэрээний 2.4-д "Зээлдэгч эргэн төлөх хугацааг чанд баримтлах нь энэ гэрээний нэн чухал нөхцөл бөгөөд зөрчвөл Зээлийн гэрээг ноцтой зөрчсөн гэж үзнэ", 3.1.2-т "Зээлдэгч нь үндсэн зээлийн болон хүүгийн төлбөрийг хавсралт хуваарийн дагуу хугацаанд нь төлж дуусгана", 3.1.5-д "Зээлийн төлөлт, түүний мэдээллийг зээл төлөгдөж дуусах хугацаандаа төлөгдөөгүй бол Монгол банкны зээлийн мэдээллийн санд байршуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан

гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

3.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх

Илрүүлэлт: 1 Мал хамгаалах сангийн санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан 353.4 сая төгрөгийн авлага, 33.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг баталгаажуулсан тооцоо нийлсэн акт, журнал болон холбогдох баримтуудыг аудитад ирүүлээгүй тул санхүүгийн тайлангийн мэдээлэл үнэн зөв, алдаагүй, эрх ба үүргийн дагуу зөв илэрхийлэгдсэн гэдгийг баталгаажуулах боломжгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Илрүүлэлт: 2 Мал хамгаалах сангийн санхүүгийн тайлангийн тодруулга тайлбар, бараа материалын (нөөцийн өвс, тэжээл, тэжээлийн будаа) тайлан, өвс тэжээлийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон актыг ирүүлээгүй тул 229.8 сая төгрөгийн нөөцийн өвс, тэжээлийн үлдэгдлийг оршин буй эсэхийг нотлох боломжгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.3-д “Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

3.5 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өглөгийн тодруулгад 377.9 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй гэж тайлагнасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан

авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Э-тайлангийн өглөгийн тодруулга тайланд үлдэгдлийг зөв ангилж бүртгэсэн байдалд хяналт тавьж ажиллах.

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Эмийн эргэлтийн сангийн авлагын үлдэгдэл 389.8 сая төгрөг болж өмнөх оноос 149.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь эмийн эргэлтийн сангаас борлуулсан эмийн үнийг цаг тухай бүрд нь тушаадаггүй, эмийн санч солигдох тухай бүрд тооллого хийж тооцоо боддоггүйгээс шалтгаалан ажиллагсадтай холбоотой авлага өссөн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" 12 дугаар зүйлийн 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Эмийн санчийн борлуулсан эмийн үнийг цаг тухайд нь тушаасан эсэхэд тавих дотоод хяналт, хариуцлагыг сайжруулах, мөн эмийн санч солигдох бүрд болон тогтмол хугацаанд эмийн тооллого хийж, тооцоо бодож эмийн үлдэгдэл болон авлагыг баталгаажуулж байх.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:1 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдээс Заамарын хөгжил ОНӨААТҮГ, Сэргэлэн нутгийн хөгжил ОНӨААТҮГ алдагдалтай ажилласан, Эко төв Жаргалант ОНӨААТҮГ байгуулагдсанаасаа хойш үйл ажиллагаа явуулаагүй, Төв Эрдэнэс ОНӨААТҮГ, Шимт бордоо органик ХХК санхүүгийн тайланг ирүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д "Төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана", 21' дүгээр зүйлийн 21.1-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид "зорилтын санал" гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 21'2-д "Зорилтын саналд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараах зүйлийг тусгана", 21'2.4-д "санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг", 77 дугаар зүйлийн 77.2.4-д "орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Алдагдалтай ажиллаж буй ОНӨААТҮГ-ын орлого, зардлын бүтцийг нарийвчлан судалж, алдагдлын шалтгааныг тогтоох, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах. Үйл ажиллагаа явуулаагүй ОНӨААТҮГ-ын хувьд байгууллагыг ямар зорилгоор байгуулсан, тухайн хэрэгцээ одоо байгаа эсэхийг үнэлэх, хэрэв хэрэгцээ, үр ашиг байхгүй гэж үзвэл татан буулгах санал гаргаж, төсвийн үр ашигтай байдлыг хангах, Сумдын Эмийн эргэлтийн санг татан буулгах асуудлыг шийдвэрлэх.

Илрүүлэлт:2 Аудитаар өгөгдсөн 752.2 сая төгрөгийн албан шаардлагаас 334.2 сая төгрөгийн буюу 44,4 хувийг, 512.8 сая төгрөгийн зөвлөмжөөс 122.8 сая төгрөгийн буюу 23,9 хувийг хэрэгжүүлэн нийт шийдвэрийн хэрэгжилт 36,1 хувьтай хангалтгүй ажилласан байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “20.3.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ”, 20.5-д “20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аудитын дүгнэлт гарснаас хойш 30 хоногт багтаан хэрэгжилтийн төлөвлөгөө гаргаж, батлуулах, төлөвлөгөөнд гүйцэтгэгч хариуцагч, хугацаа, хяналт тавих шат бүрийг тодорхой тусгах, албан шаардлага болон зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй бол гүйцэтгэгч албан тушаалтанд хариуцлага тооцох тогтолцоог хэрэгжүүлэх (ёс зүйн хороо, сахилгын зөвлөлөөр оруулах гэх мэт) шийдвэрийн хэрэгжилтийн хувьтай нь уялдуулан гүйцэтгэлийн үнэлгээг холбож ажиллах.

Илрүүлэлт:3 Аймгийн Төсөвт байгууллага, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, орон нутгийн тусгай сангуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хуралд зориулсан шилэн дансны мэдээллийг хэрхэн хянах, хөндлөнгийн хяналтыг хийхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар сургалт зохион байгуулах, шилэн дансны мэдээлэлд хийсэн хөндлөнгийн хяналтын талаарх мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/											
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж
							Залруулсан		Залруулаагүй		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
ТЕЗ	7	9,062.1	1	1,186.7	6	7,875.4	7	9,062.1			
ТТЗ	27	5,657.7	9	1,308.5	18	4,349.2	27	5,657.7			
ТШЗ	111	28,294.4	31	16,566.0	80	11,728.4	109	28,294.4	2	0	2
ОНӨГ	4	5,031.0	1	4,218.5	3	812.5	4	5,031.0			
ОНТС	40	708.1	1	4.3	39	703.8	40	708.1			
Дүн	189	48,753.3	43	23,284.0	146	25,469.3	187	48,753.3	2	0	2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/										
			Үүнээс										
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			ууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	12	7,600.7	2	1.8	4	6,301.3	4	680.5				2	617.1
ТТЗ	34	4,067.0			7	607.8	25	3,459.2	2	2			
ТШЗ	258	15,692.2	82	159.7	73	6,843.9	92	6,815.5	8	3	1,397.8	3	475.3
ОНӨГ	14	186.4	1	3.2	4	65.8	9	117.5					
ОНТС	94	4,097.2	9	26.7	41	1,192.3	42	2,361.7	2	2	516.4		
Дүн	412	31,643.5	94	191.4	129	15,011.2	172	13,434.4	12	7	1,914.1	5	1,092.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

											/сая төгрөгөөр/
Байгуул лагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтн ы тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ТЕЗ	1	-							1	3	
ТТЗ	10	-			2		8				
ТШЗ	21	-			1		20		1	1	
ОНӨГ	1	-			1						
ОНТС	54	47,668.0			8	2,747.5	43	38,895.9	3	3	6,024.6
Дүн	87	47,668.0	-	-	12	2,747.5	71	38,895.9	5	7	6,024.6
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
ТТЗ	-	-									
ТШЗ	1						1				
Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-
дүн	88	47,668.0	-	-	12	2,747.5	72	38,895.9	5	7	6,024.6

5. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг

Утас: 70273623, И-мэйл: tuv_zdtg@tov.gov.mn

2025.04.18 № 05/658

танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгдсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын тайлангаар гарах зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч хамтран ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА _____ Ю.БЯМБАЦОГТ

- 4125020860

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2-р байр
Утас: +976 70272582, +976 70273465
И-мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn